



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/175

Батширээт сум

Мотоцикл, мопедийн хөдөлгөөнийг түр
хугацаагаар хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдан халтиргаа гулгаа үүсэж, тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн нөхцөл байдал хүндэрсэн үед мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор сумын нутаг дэвсгэрт мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохыг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл түр хугацаанд хориглосугай.

2. Ард иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч, Ахлах дэслэгч (Р.Болор-Эрдэнэ), багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ



232501343